


Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр
тогтоолын гуравдугаар хавсралт




“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга² (Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байллын талаар товч мэдээллийг тайлагнана)

Ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд: “Ёс зүйн дэд хороо”-ны 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд нийт 16 үйл ажиллагааг тусган, Газрын даргаар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний дагуу гомдол, мэдээллийг хүлээж авах QR код бүхий зурагт холбоос, саналын “Хайрцаг”-ийг Газрын мэдээллийн самбар болон дотоод сүлжээнд байршуулан, ажилтан, албан хаагчдад мэдээлэл хүргэн ажилласан. Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороонд 1 санал, гомдол ирж, Ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцүүлэн холбогдох хуулийн хүрээнд “Ёс зүйн зөрчил биш” гэсэн дүгнэлт гаргаж, хуулийн хүрээнд зөвлөмж гарган, зөвлөмжийг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр баталгаажуулан, Газрын дарга болон холбогдох нэгжийн дарга, албан тушаалтанд танилцуулсан.



“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ажилтан, албан хаагчдын ёс зүй, харилцаа, хандлага”-ын талаарх судалгааг 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд цахимаар авч, судалгаанд нийт **43** ажилтан, албан хаагч хамрагдсан. Судалгааны үр дүнг нэгтгэн, Газрын даргад танилцуулан баталгаажуулж, судалгааны дүгнэлт, зөвлөмжийг Газрын дотоод сүлжээнд “НХОГ” группд байршуулан нийт удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагч нарт мэдээлэл хүргэж ажилласан. Судалгааны дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн, хэрэгжүүлж ажилласан.



Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд: Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ёс суртахууны тухай мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилготой “Ёс зүйтэй албан хаагч”, “Бид ёстой-зүйтэй хамт олон”, “Хүндэлье, Энэрье-2025” зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 11 удаагийн постер мэдээлэл, уриалга, 5 удаагийн сургалт, “Хамт олондоо талархах, урам зориг өгөх, уучлал хүсэх өдөр”, “Хүндэлье, Энэрье” уриалга, “Ажлын цагийн хоцролтгүй хэлтэс” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

Газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/69 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ажилтны ёс дүрэм”-ийг хоёрдугаар хавсралтаар “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн”-ийг

5 хүний бүрэлдэхүүнтэй тус тус батлан хэрэгжилтийг ханган ажиллаж, Ёс зүйн дэд хорооны ажил тогтмолжсон. “Ёс зүйн дэд хороо”-ны 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд нийт 16 үйл ажиллагааг тусган, Газрын даргаар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар 93,7 хувьтай байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
✓ Газрын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа тогтмолжсон. ✓ Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол явуулсан. ✓ Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гараагүй.	-
Санал:	
Саналгүй	

Шалгах хэсэг:

- Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан:

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар”-ын
Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн
дарга

Б.Ганзориг

Ёс зүйн дэд хорооны дарга:

Захиргааны хэлтсийн дарга Ц.Гүрбадам

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:

Захиргааны хэлтсийн Тогтоол,
шийдвэрийн биелэлт

хариуцсан мэргэжилтэн Г.Ижилмаа

Ес зүйн хорооны 2025 оны 1 дугаар сарын 11-ний өдрийн 1 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

АТА11169 8448906
9023111371

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЕС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Авбал зохиох оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3	4	5	5
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]	1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]	1	1	10
3		Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0.5	0,5	5
		Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0.5	0,5	5
		Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0.5	0,5	5
	Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0.5	0,5	5	
Хэсгийн оноо			4		40
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (аварсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)	1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]	1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]	1	1	10
Хэсгийн оноо			3		30
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]	1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (Гомдол ирээгүй бол 1 оноо авна. нийт ирүүлсэн өрөөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)	1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]	1	1	10
Хэсгийн оноо			3		30
Үнэлгээний нийт оноо, хувь			10	10	100

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} \cdot 100\%$$

Тайлбар:

- [1] Байгууллагын өөрийн болон харьяа салбар байгууллагад өгсөн үнэлгээ
[2] Авсан оноог 10-аар үржүүлж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”
[4] ЕЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шигнэлтээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн баталсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ
[5] ЕЗХ-ны 2025 оны 06 дугаар “Аргачлал батлах тухай” тогтоол
[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх хэсэг, ЕЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ес зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 4.1.3, мөн оны 15 дугаар “Сургалтын агуулга, сэдэв батлах тухай” тогтоол
[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт
[8] ЕЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын 8.3.3, мөн оны 07 дугаар “Ес зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах өргө хэмжээний тухай” тогтоол
[9] ЕЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар “Загвар батлах тухай” тогтоол
[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт
[13] ЕЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалт
[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт
[15] ЕЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.